

ДЭЛГЭРЦОГТ: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ АВЧ

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023-11-22

Амардалай

№	Өгсөн үүрэг даалгавар	Үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	хувь
1	2	3	4	5	6	7	8
1	Засгийн газрын 374 дүгээр тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг аймгийн сайтад 05 сарын 01-ний дотор багтаан бүрэн байршуулах	Мэдээлэл оруулсан байх	Шалгуур үзүүлэлтийг хангах	90,0	90,5	Шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг Дундговь сайтад бүрэн байршуулав. 98 шалгуурын дундаж хувь 44.67 байна.	45
2	Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдалд улирал бүр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангах	Мэдээлэл оруулсан байх	Шалгуур үзүүлэлтийг хангах	90	91	Шилэн дансны мэдээллийг бүрэн шинэчилж, улирал бүр хяналт тавьж ажиллаж байна. Шилэн дансанд 107 мэдээлэл оруулахаас 107 мэдээлэл оруулсан. хэрэгжилт 99,7%тай.	99,7
3	Тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх мэдээллийг Сангийн яамнаас баталсан загвар маягт Хавсралт 1-ийн дагуу гаргаж, сумын ИТХ-аар батлуулан хэрэгжилт үр дүнг тооцож байх.	Жилийн төлөвлөгөө батлуулсан байх	үр дүнг тооцох	68	70	2023 оны сумын ОНХС-ийн төсөл хөтөлбөр арга хэмжээг Сумын ИТХ-ын 2023 оны 06 сарын 29 ний өдрийн 07 дугаар тогтоолоор шилжих 2, шинээр эхлэх 1, их засвар, тохижилт 3, Малын тоо толгойн албан татвараар хэрэгжих 6 нийт 12 хөтөлбөр арга хэмжээг Сангийн яамнаас баталсан загвар маягтын дагуу баталсан. Хэрэгжилт 11 сарын 23 ны байдлаар 74.2 хувьтай	100

1	2	3	4	5	6	7	8
4	Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан аймгийн ИТХТ-ийн 2020 оны 06 тогтоолын 2 дугаар хавсралтаар дагуу сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилт үр дүнг Орон нутгийн өмчийн газарт 6.11 сарын 10-ны дотор тайлагнах.	Жилийн төлөвлөгөөг батлуулсан байх	Хөрөнгийн тооллогыг явуулах /тийм, үгүй/	Тийм	Тийм	Сумын өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр батлуулан ажлын төлөвлөгөөг 11 заалттай баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90,9 хувьтай. Хэрэгжилтийн үр дүн нь хагас жилийн тооллогод үндэслэн төрийн байгууллагуудаар явж хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж ажиллахад ЭМТ, ЕБС-ийн хөрөнгийн ашиглалт хадгалалт туйлын хангалтгүй байсан тул албан шаардлага хүргүүлэн ажиллаж, шаардлагын дагуу дахин хянаж шалгаж ажилласан.	90
5	Улс болон орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь сар бүр жигд биелүүлэх.	Төлөвлөгөөг батлуулах	Сар бүр, нэр төрлөөр биелүүлэх	100	100	Улсын төсвийн орлогын төлөвлөгөө 9100.0 мян.төг төвлөрөхөөс 8700.0 мян.төг төвлөрч төлөвлөгөөний биелэлт 95.6 %, <p>Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 15000,0 мян.төг төвлөрөхөөс 16800,0 мян.төг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 112%,</p> <p>ОНО-ын төлөвлөгөө 233625.2 мянган төгрөг төвлөрөхөөс 227361.7 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 97.3%, Улс, аймаг, орон нутгийн төсөвт нийт 18 төрлийн орлого төвлөрүүлэхээс 15 төрлийн орлогыг 100 болон түүнээс дээш хувиар давуулан биелүүлсэн. нэр төрлөөр хэрэгжилт 83,3% гүйцэтгэл 101,6%</p>	100

1	2	3	4	5	6	7	8
6	Цахим албан бичгийн дотоод үйл ажиллагааны цахимжуулалт, цахим албан хэрэг хөтлөлтийн тайланд улирал бүр дүгнэлт хийж, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст цахимаар ирүүлэх	тайланг хүргүүлэх	улирал бүр /тийм, үгүй/	-	тийм	Санал өргөдөл гомдлын тайланг улирал бүр (1,2,3-р улирал) Аймгийн ЗДТГ-ын СӨГ хариуцсан мэргэжилтэнд цахимаар болон бичгээр хүргүүлэн ажиллаж байна. Мөн сумын Засаг даргын Захирамж, байгууллагын дарга нарын Тушаалыг улирал бүрийн 15-ны дотор (1.2.3-р улирал) Аймгийн Хууль эрх зүйн хэлтсээр хянуулан зөвлөмжийн дагуу алдаа дутагдлаа засаж сайжруулан ажиллаж байна. Зөвлөмжийн дагуу албан хаагчдад захирамж, албан бичгийг хэрхэн төлөвлөх, хууль дүрэм журмыг судлах, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалтыг зохион байгуулснаар албан хэрэг хөтлөлтөнд буруу бичилт болон алдаа маш бага гарсан үр дүн харагдаж байна.	100
7	Цахим хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, аймаг орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, фэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэх талаар тогтмол анхаарч үр дүнг сар бүр тооцон ажиллах	хандалт нэмэгдүүлэх	хандалтын тоо	25000	27000	Сумын ЗДТГ-ын албан фэйж хуудсаар аймаг, сум орон нутгийн мэдээллийг тогтмол хүргэж хандалтын тоог 28 хоногт 12.257 жилдээ 147.084 хүргээд байна.Өмнөх жилийн энэ үетэй харьцуулахад 8 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Үр дүн: Иргэдийн хандалт нэмэгдсэн, мэдээллийг үнэн зөв бодитой хүлээж авдаг, зохион байгуулж байгаа ажилд оролцох оролцоо сайжирсан.	100
8	Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтын сайжруулж, цаг бүртгэл, үүрэг даалгаврын цахим ситемд шилжиж, нийт	сургалт зохион байгуулах	тийм, үгүй	тийм	тийм	Байгууллагын дотоод удирдлагын ер системийн ашиглалт албан бичиг боловсруулах, үүрэг даалгаварыг системд байршуулж ашиглах албан хаагчдын цахим ур чадварыг	100

1	2	3	4	5	6	7	8
	албан хаагчдын цахим ур чадвар, тоон боловсролыг дээшлүүлэх					нэмэгдүүлэх сургалтыг аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн А.Мөнгөнийг урьж зохион байгуулан 18 албан хаагч хамрагдсан. Үр дүн: Сургалтыг явуулснаар цахим системээр албан бичгийг боловсруулдаг, илгээдэг, ирсэн бичгээ хянаж шийдвэрлэдэг, үүрэг даалгавар бичиж хянаж дүгнэдэг болсон байна.	
9	Гадаад, дотоод сүлжээний зохион багуулалт, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх замаар байгууллагын ERP болон төрийн сангийн системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангаж албан хаагчдын ажиллах нөхцөл боломжоор хангах.	интернэтийн хурдыг нэмэгдүүлэх	шийдвэрлэсэн эсэх /тийм/ үгүй/	5мгв	10мгв	Байгууллагын интернэт хурд 5мгв байсныг 10мгв болгон нэмэгдүүлж интернэт сааталгүйгээр ERP систем болон Төрийн сангийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга 2 албан хаагчид тоон гарын үсэг авсан ашиглаж байна. 100% Үр дүн: Тоон гарын үсэгтэй болсноор албан бичгийг илгээхэд хялбар болсон. байгууллагын дотоод системээр үүрэг даалгавраа өгөх, хянах, албан бичгээ шийдвэрлэхэд маш хялбар болж цаасны хэрэглээ багассан.	100
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах сумын орон тооны бус дэд салбар зөвлөл болон Залуучуудын хөгжлийн зөвлөлийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан, төлөвлөгөө гарган батлуулж, тус зөвлөлүүдийн төлөвлөгөөг 4 сарын 15-ны дотор Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлэх	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	90	91,0	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах сумын орон тооны бус дэд салбар зөвлөлийг 2021 оны 06 сарын 15-ны өдөр засаг даргын захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй батлуулж, 2023 оны 03 сарын 15-нд зөвлөлийн төлөвлөгөөг батлуулж нийгмийн бодлогын хэлтэст явуулсан. Хэрэгжилтийн хувь 100%	100

1	2	3	4	5	6	7	8
11	0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх	Үзлэгийг зохион байгуулах	Хамрагдалтын хувь	26	80	Тус сумын хүн амын бүртгэлд 0-17 насны 499 хүүхэд бүртгэлтэй бөгөөд эрт илрүүлэгт нийт 319 хүүхэд хамруулсан нь байнгын оршин суудаг хүүхдүүдээ бүрэн, хичээл сургууль амарсан цаг үед орон нутагт ирсэн хүүхдийг мөн үзсэн байна. Хамрагдалтын хувь 63,92%	70
12	Сумын нийт өрхийн 50-аас доошгүй хувийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг Соёл, урлагийн газарт 6,11 сарын 10-ны дотор тайлагнах	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	90	90	Угийн бичиг хөтлөх ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжилтийн талаар СУГ-аас 2023.06.06-ны өдөр цахим уулзалтаар мэдээлэл авсан. Сумын нийт өрхийн 60 хувь 2-5 үе хөтөлсөн. Бүтээлч залуус өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж угийн бичгийг хэрхэн хөтлөх арга зүйгээр хангах сургалтанд шинээр 20 өрхийг хамруулж ажиллалаа. Малчин 63 өрхөд гарын авлага материал хүргүүлсэн. Угийн бичигтэн өрх шалгаруулах болзлын хүрээнд 3 өрхийг шалгаруулсан. Үр дүн: нийт өрхийн 51,9 хувь 2-5 үе угийн бичгийн бичиглэл зураглалыг хийж хөтөлсөн. Нэгдсэн судалгаатай болсон. Угийн бичигтэн байгууллага хамт олон болон өрхүүдтэй болсон. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь	100
13	Байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, явцын тайланг Нийгмийн бодлогын хэлтэст 6,11 сарын 10-ны дотор ирүүлэх	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	80	85	Сумын Хэлний бодлогын салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэлэлцэн баталж төлөвлөгөөний дагуу “Үндэсний бичгийн тээгч, түгээгч” уралдааныг иргэдийн дунд, “Цахим бичвэр”-ийн уралдааныг төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж шалгарсан 2	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>иргэн, 12 төрийн албан хаагчдыг Аймгийн Үндэсний бичиг үсгийг “Тээгч-түгээгч”, “Цахим бичвэр”, “Монгол бичгийн сорил” зэрэг уралдаанд амжилттай хамруулсан. Мөн Монгол бичгийн анги нийтийн улсын олимпиадад 7 дүгээр ангийн 12 хүүхэд хамрагдаж 6-р байр эзэлсэн.</p> <p>Байгууллагууд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө албан хаагчдаа монгол бичгийн сургалтад хамруулах, дадлагажуулах, сургах ажил арга хэмжээг төлөвлөн оруулснаар анхан шатны модуль сургалтыг ахмад багш Д.Төмөрчулуун сумын Хэлний бодлогын зөвлөлтэй хамтран зохион байгуулж 34 албан хаагч хамрагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 86%</p>	
14	<p>Эрх зүйн хөтчүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулан, судлан сурталчлах хууль эрх зүйн актын жагсаалтын дагуу улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор ХЭЗХ-т ирүүлэх</p>	<p>Сургалт зохион байгуулах</p>	<p>Эрх зүйн сургалт сурталчилгааг явуулах</p>	<p>Нийт иргэдийн 13%-д</p>	<p>Нийт иргэдийн 15%-д</p>	<p>Эрх зүйн хөтөч нарыг чадавхжуулах зорилгоор 1 удаагийн сургалт, цахим сургалт 1 удаа зохион байгуулан бүх эрх зүйн хөтөч болон мэргэжилтнүүд бүрэн хамрагдлаа. Эрх зүйн хөтөч аяны цүнх 3-ыг бүтээж айл өрх, иргэдээр хууль эрх зүйн гарын авлага болон зөвлөгөө зөвлөмж зэргийг нийтдээ 248 иргэнд хүргэж ажилласан. Төрийн албан хаагчдын дунд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх, Үндсэн хуулийн ач холбогдол, Татварын хуулийн талаар сургалтыг зохион байгуулж, Гэр бүлийн Дэвжээ тэмцээнийг явуулж давхардсан тоогоор 1798 иргэнд үйлчилсэн. Эрх зүйн сургалт, сурталчилгаанд нийт иргэдийн 16.8% хамрагдсан байна.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
15	Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 6,11 сарын 10-ны дотор тайлагнах	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	90	91	“Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган 2 зорилт, хүрээнд 17 арга хэмжээг төлөвлөн жилийн хэрэгжилт 91,65 хувьтай хэрэгжсэн байна. Тайланг ТЗУХ-т 11-р сарын 10-ны өдөр хугацаандаа хүргүүлсэн. Үр дүн: Энэхүү хөтөлбөр хэрэгжснээр 5 багш сургалтын төлбөр, 1 албан хаагч нийгмийн баталгааны дэмжлэгийг хүртсэн. Мөн сумын 13 төрийн албан хаагч төрийн албан хаагчийн орон сууцанд орсон байна.	100
16	Төрийн албаны тухай хуулийн 55.3-ын дагуу байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, үр дүнг хагас бүтэн жилээр тооцож байх.	Төлөвлөгөөг батлуулах	Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцох	95	95,2	Байгууллага бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг урьдчилсан байдлаар тооцож дүгнэхэд Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, сургалтын хөтөлбөрийн дундаж-94.6%: /ЗДТГ-94, хүүхдийн цэцэрлэг-96, Соёл-96, ЕБС-92, ЭМТ-95/ нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн дундаж- 95,6%: ЗДТГ-96, Хүүхдийн цэцэрлэг-98, соёл-98, ЕБС-90, ЭМТ-96 Нийт дундаж-95,1%	99,89

Үнэлгээ: 100-11, 99-2, 90-1, 70-1, 45-1,

94,03%

ХЯНАСАН:ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:ЗДТГ-ЫН ДАРГА

С.НАРАНТУНГАЛАГ